



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 57

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын  
худалдаагаар худалдах зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 111,935,742.00 /нэг зуун арван нэгэн сая есөн зуун гучин таван мянга долоон зуун дөчин хоёр/ төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 2 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга Н.Энх-Амар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

000012'

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2020 оны 03 дугаар сарын 10-ний өдрийн  
 37 дугаар тогтоолын хавсралт

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын үндсэн хөрөнгөд  
 бүртгэлтэй нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашин

Д/д	Автомашини марк, улсын дугаар, арал	Үндэслэсэн, ашиглагд, орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Сэргээн босголт (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Ниссан теана, 47-08 УНМ, арал № JN1BAUJ32Z0000136	2008/2008	386000	45,833,000.00	45,833,000.00	0	0	1,000,000.00
2	Пажеро, 44-81 УБЛ, арал№ JMY1NV76W5J000795	2004/2004	332950	66,102,742.00	66,102,742.00	0	0	1,000,000.00
	Нийт дүн			111,935,742.00 /нэг зуун арван нэгэн сая есөн зуун гучин таван мянга долоон зуун дөчин хоёр/	111,935,742.00 /нэг зуун арван нэгэн сая есөн зуун гучин таван мянга долоон зуун дөчин хоёр/	0	0	2,000,000.00 /хоёр сая/